

БАТЛАВ  
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
С.ЭНХБАЯР

2024 оны 5 дугаар сарын ... өдөр

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 73 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ДЭЭВЭР ЗАСВАРЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 6 дугаар тогтоол.
2	Байршил, барилгын хэмжээ	- Хан-Уул Дүүргийн 7-р хороо 73 дугаар цэцэрлэгийн хуучин барилга
3	Зориулалт хүчин чадал	- 73 дугаар цэцэрлэгийн хуучин барилгын дээвэр засварын ажил
4	Одоогийн байдал	- Хуучин байрны дээврийн хамгаалалтын хар цаасан давхарга нь парапетан хана болон нийт хэсгүүдэд хөндийрч, хучилтанд зай засвар, хагарал үүссэн.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, угсралт засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой .
8	Төсөл гүйцэтгэх үе шат	- Гүйцэтгэгч байгууллага зургийн шатанд илүү дэлгэрэнгүй талбайн судалгаа хийх. - 73 дугаар цэцэрлэгийн эрхлэгчтэй зөвшилцсөний дараа батлагдсан төсөвт багтаан ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах. - Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/. - Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/. - Батлагдсан зураг төсөвийн дагуу дээвэр засварын ажил гүйцэтгэх.
9	Төлөвлөлтөд тавигдах шаардлага	- Тухайн ажлын талбайн онцлогт нийцүүлэн цутгамал дээврийн ажлыг БНБД, MNS норм, стандартуудыг баримтлан төлөвлөх.

		<ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн ус зайлуулах хоолойн ажиллагааг шалгаж нягтлан шаардлагатай арга хэмжээг авах.</li> <li>- Дээврийн агааржуулах хоолой, бохирын яндан хоолойд малгайвч төмөр угсрах.</li> <li>- Бусад дээврийн хийц болон дээврийн орон зайд хамрагдах зайлшгүй хийгдэх ажил байгаа эсэхийг нягтлан шалгаж ажлын зураг боловсруулан тоо хэмжээ гаргах.</li> </ul>
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b><u>Монгол Улсын хуулиуд</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b><u>Норм, нормативууд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн хучилт /БНбд31-02-03/</li> <li>- Дээврийн ажил /БНбд31-07-05/</li> <li>- БД 31-108-08</li> <li>- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05</li> <li>- БД 23-103-10 Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт</li> <li>- MNS 6303:2016 Дээвэр болон барилга байгууламжид хэрэглэх ус, уур тусгаарлах хуйлмал материал. Техникийн ерөнхий шаардлага</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
11	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Байрилгын ус зайлууллах хоолойг шинэчлэн засварлах.</li> </ul>
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
13	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Дээврийн засварын ажилд хэрэглэгдэх материалууд нь бүгд гарал үүслийн гэрчилгээтэй, барилгын материалын лабораториар баталгаажсан сертификаттай, Монгол улс болон олон улсын чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх.</li> <li>- Засварын ажилд хэрэглэгдэх машин механизмын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах</li> <li>- Өндөрт ажиллах ХАБЭА-н дүрэм, журмыг чанд мөрдөх.</li> </ul>

ХЯНАСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ИНЖЕНЕР М.БАЯРБЯМБА

Одоо байгаа объектын фото зураг



Galaxy S22 Ultra



Galaxy S22 Ultra